

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны ... дугаар
сарын-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил,
мэргэжлийн жишиг цалин батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тэтгэвэр тогтооход баримтлах “Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин”-г хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Батжаргал)-т даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/136 дугаар тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

Х.БУЛГАНТУЯА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн А/..... дугаар тушаалын хавсралт

ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ҮНДЭСНИЙ АЖИЛ,
МЭРГЭЖЛИЙН ЖИШИГ ЦАЛИН

(төгрөгөөр)

| № | Үндсэн бүлэг | 1990 он ба түүнээс өмнөх | 1991 он | 1992 он | 1993 он | 1994 он |
|----|--|--------------------------|---------|---------|---------|---------|
| 1 | Менежер | 800 | 1600 | 2800 | 7100 | 12600 |
| 2 | Мэргэжилтэн | 650 | 1300 | 2250 | 5700 | 10200 |
| 3 | Техникч болон туслах, дэд мэргэжилтэн | 580 | 1160 | 2000 | 5060 | 9050 |
| 4 | Контор, үйлчилгээний ажилтан | 450 | 900 | 1540 | 3850 | 7850 |
| 5 | Худалдаа, үйлчилгээний ажилтан | 430 | 860 | 1470 | 3650 | 6500 |
| 6 | Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан | 420 | 840 | 1430 | 3550 | 6350 |
| 7 | Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан | 510 | 1020 | 1750 | 4400 | 7850 |
| 8 | Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч | 550 | 1100 | 1900 | 4800 | 8500 |
| 9 | Энгийн ажил, мэргэжил | 350 | 700 | 1200 | 2900 | 5150 |
| 10 | Зэвсэгт хүчний ажил мэргэжил | 600 | 1200 | 2080 | 5250 | 9350 |